



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/145/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.dornogovi@audit.gov.mn](mailto:www.dornogovi@audit.gov.mn)

Сайншанд сум

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

|                                                |                                                   | /сая төгрөгөөр/              |                  |
|------------------------------------------------|---------------------------------------------------|------------------------------|------------------|
|                                                | Үзүүлэлт                                          | 2020.12.31                   | 2021.12.31       |
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                              |                  |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 61.4                         | 258.2            |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 248.5                        | 314.9            |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>309.9</b>                 | <b>573.1</b>     |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | 0.02                         | 13.4             |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 309.9                        | 559.7            |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>309.9</b>                 | <b>573.1</b>     |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                              |                  |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 351.6                        | 751.0            |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 347.0                        | 461.3            |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>4.6</b>                   | <b>289.7</b>     |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | (6.8)                        | (39.9)           |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>(2.2)</b>                 | <b>249.8</b>     |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                              |                  |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 309.9                        | 309.9            |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 0                            | 249.8            |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>309.9</b>                 | <b>559.7</b>     |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                              |                  |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 342.6                        | 413.9            |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 339.3                        | 408.3            |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>3.3</b>                   | <b>5.7</b>       |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>(3.3)</b>                 | <b>(4.5)</b>     |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 |                              |                  |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>0</b>                     | <b>1.2</b>       |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |                              |                  |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл |                              | 1.2              |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   | <b>Батлагдсан төлөвлөгөө</b> | <b>Гүйцэтгэл</b> |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>351.9</b>                 | <b>346.7</b>     |
|                                                | Урсгал зардал                                     | 351.9                        | 346.7            |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                              |                  |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>351.9</b>                 | <b>346.8</b>     |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           | 320.3                        | 320.3            |
|                                                | Орон нутгийн төсвөөс санхүүжих                    | 12.7                         | 10.6             |
|                                                | ЭМД-ын сангаас санхүүжих                          | 18.9                         | 15.9             |

## Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны чиглэлээ “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрд сэтгэл ханамжтай, чанартай, хүртээмжтэй хүргэх, халдварт өвчнийг бууруулах, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлнэ ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудит болон аудитор байхгүй.

## **Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 358.8 сая төгрөгийн 17 орлогын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 51.6 сая төгрөгийн 6 худалдан авалтын гүйлгээг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад нийт 15 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43.1 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 51.6 сая төгрөгийн худалдан авалтын 6 гүйлгээг мэдээлээгүй байна.

### **3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

#### **Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг чанартай хийсэн эсэхэд анхаарал хандуулах нь зүйтэй.

#### **Тав. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 21.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 12.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

## **Албан шаардлага**

1. Санхүүгийн тайланд тусгасан тусгагдсан өр төлбөрөөс 4.1 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй, татварын байгууллагын тодорхойлолтоор 7.8 сая төгрөгийн авлага байхад санхүү бүртгэлд "0" байна. Мөн тодорхой бус 1,891.9 мянган төгрөгийн өрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС 1-ын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тус байгууллагын Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроосон, 43.1 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 51.5 сая төгрөгийн худалдан авалтын 6 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.4-т Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6 дугаар зүйлийн 6.4.5-т "...орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр,..." тус тус мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тус байгууллагын нийт хөрөнгийн 32.4 хувийг бараа материал, хувийг үндсэн хөрөнгө эзэлж байгаа бөгөөд жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

## **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал:*

- 1.1. *Илрүүлэлт:* 2021 онд аж ахуйн нэгж байгууллагуудаас и-баримтгүй 21.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын

тухай хуулийн 4.1.14-т "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим и-баримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

2. Эргэлтийн бүс хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Ашиглагдах хугацаа тавигдаагүй 3 хөрөнгөнд элэгдэл тооцогдоогүй байна. Энэ нь УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ийн 66-д "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилна" гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Элэгдэл дутуу тооцогдсон хөрөнгийн элэгдлийн зардлыг залруулан бүртгэх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/15 тоот тушаалаар олгосон 12.0 сая төгрөгийн, олгосон вакцины урамшууллаас НДШ суутгаагүй, тайлагнаагүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно, 16 дугаар зүйлийн 16.4 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч гүйцэтгэнэ" заалтуудыг зөрчсөн.

3.2 Өгсөн зөвлөмж: Шагнал урамшуулал нь шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орох тул хуулийн дагуу шимтгэлийг ногдуулж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | +                        | +                           |                    |                 |                         | +              |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 3 | ЗГТС                        |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 4 | ТТЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 5 | ТЕЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
|   | НИЙТ                        |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн |      | Үүнээс    |     |               |     |                 |     |         |      |
|---|-----------------------------|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|------|
|   |                             |                      |      | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |      |
|   |                             | Тоо                  | Дүн  | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн  |
| A | 1                           | 2                    | 3    | 4         | 5   | 6             | 7   | 8               | 9   | 10      | 11   |
| 1 | ТШЗ                         | 6                    | 21.7 | -         | -   | -             | -   | 3               | 9.7 | 3       | 12.0 |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                      |      |           |     |               |     |                 |     |         |      |
| 3 | ЗГТС                        |                      |      |           |     |               |     |                 |     |         |      |
| 4 | ТТЗ                         |                      |      |           |     |               |     |                 |     |         |      |
| 5 | ТЕЗ                         |                      |      |           |     |               |     |                 |     |         |      |
|   | НИЙТ                        | 6                    | 21.7 | -         | -   | -             | -   | 3               | 9.7 | 3       | 12.0 |